



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/202

Номгон

ГТусгай зориулалтаар агнуурын амьтан агнах
дуудлага худалдаа зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 25 дугаар зүйлийн 25.5, 29¹ дүгээр зүйлийн 29¹.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.1, 8.1 дүгээр зүйлийн 8.1.1.23 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай" 89 дүгээр тогтоолын 2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/1339 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдааны зарыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлж, 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2.Дээрх дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдааг холбогдох хууль, журамд нийцүүлэн, ил тод, нээлттэй зохион байгуулж дуудлага худалдааны тайлан, баримт бичгийг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор архивд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсэг (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

02401944

Аймгийн Засаг даргыг А.О.Оны, Нэгдүгээр сарын 01-ний өдрийн 01/01-дугаар захирамжийн нэгдүгээр хайррэгт



ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АГНУУРЫН АМЬТАН АГНАХ
ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Сарангарав Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Г.Ганчулуун Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга

Б.Намуун Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ш.Даваабат Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Э.Долгорсүрэн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Ш.Энхбилэг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Э.Ганзориг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

_____оОо_____

Аймгийн Засаг дарга Д.О.Оны 2014 дүгээр сарын 01-ний өдрийн 11 дугаар захирамжийн хоёр дугаар зөвсрэлт

УДИРДАМЖ

Тусгай зориулалтаар ан амьтан агнах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг зохион байгуулах тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6, 8.1.23-д заасан зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар олгохдоо Амьтны тухай хуулийн 29¹ дүгээр зүйлд тухайлан зааж тодорхойлоогүй харилцааг энэхүү удирдамжаар зохицуулна.

1.2.Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах зөвшөөрлийн дуудлага худалдаа /цаашид “дуудлага худалдаа” гэх/-г явуулах удирдамж, ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар дуудлага худалдаа эхлэхээс өмнө батална.

1.3.Дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Хууль, эрх зүйн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар тус бүрээс төлөөлөл оролцуулж байгуулна. /цаашид “ажлын хэсэг” гэх/. Дуудлага худалдаагаар тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар голлох үүрэгтэй оролцож, удирдан зохион байгуулна.

Хоёр. Дуудлага худалдаа зохион байгуулахад баримтлах зарчим

- 2.1.Нээлттэй, ил тод байх;
- 2.2.Тэгш, шударга,оролцоог хангасан байх
- 2.3.Холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг чанд мөрдөх

Гурав. Дуудлага худалдаа явуулах дараалал

- 3.1.Дуудлага худалдааны бэлтгэл ажлыг хангах;
- 3.2.Дуудлага худалдааны товыг зарлан мэдээлэх;
- 3.3.Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх,баталгаажуулах;
- 3.4.Дуудлага худалдааг эхлүүлэх, дуусгавар болгох;
- 3.5.Дуудлага худалдааны ялагчийг зарлах, баталгаажуулах
- 3.6.Ан агнах зөвшөөрлийн бичиг олгох

Дөрөв. Дуудлага худалдааны бэлтгэл ажил

2.

4.1.Хуульд заасан шаардлагад нийцсэн, төрийн байгууллагуудад ашиглагдаж туршигдсан, программ хангамж ашиглах туршилт хийж бэлэн болгоно. Аудио/видео хэлбэрээр үнийн санал өгөх, аудио/видео бичлэг хийж хадгалах баталгаажуулах, зохион байгуулагчид болон бүх оролцогчид харилцан хяналт тавих боломж бүхий **zoom** буюу түүнтэй төстэй программ ашиглана.

4.2.Дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүдэд сургалт хийж дадлагажуулна.

Тав. Дуудлага худалдааны зарыг нийтэд мэдээлэх:

5.1.Дуудлага худалдааны зар /цаашид “зар” гэх/-ыг уг дуудлага худалдаа явуулахаар товлосон өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ:

5.2.Дуудлага худалдааны зард:

- Дуудлага худалдааг явуулах программ хангамж
- Дуудлага худалдааны тов, эхлэх өдөр, цаг, минут
- Агнуурын амьтны зүйлийн нэр, тоо толгой,
- Босго үнэ, дэнчингийн хэмжээ
- Дэнчин төлөх дансны дугаар,
- Дэнчин төлөх сүүлийн хугацаа
- Дуудлага худалдаанд хэлэх үнийн дээд, доод хязгаар
- Оролцогчдыг бүртгэж эхлэх болон бүртгэлийг хаах цаг
- Дуудлага худалдаа зохион байгуулах цахим хуудасны мэдээлэл /дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамж, харилцах утасны дугаар/ бусад шаардлагатай мэдээллүүдийг багтаана:

Зургаа. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх

6.1.Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг хүлээн авах хугацааг дуудлага худалдааны зар зарлагдсан цагаас эхлэн, дуудлага худалдаа эхлэхээс **24** цагийн өмнө хаана.

6.2.Дэнчин төлсөн хугацаа,дэнчингийн мөнгөн дүн, оролцох төлөөлөл болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийг батлах баримт бичиг зэргийг хянан үзэж,шаардлага хангаагүй бичиг баримтыг бүрдүүлэхийг дуудлага худалдаа эхлэхээс **12** цагийн өмнө хүсэлт гаргагчид мэдэгдэж баримт бичгийн болон бусад зөрчлөө арилгах боломж олгоно.

6.3.Оролцогчдын ирүүлсэн хүсэлт, шаардлагатай баримт бичгийг хянан баталгаажуулж, шаардлага хангасан оролцогчдод хүсэлтийг хүлээн авснаас хойш **12** цагийн дотор багтааж дуудлага худалдаанд оролцох эрхийг баталгаажуулсан

мэдэгдлийг цахим дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамжид нэвтрэх нэр, нууц үг, бусад мэдээллийн хамт хүргүүлнэ.

6.4. Дуудлага худалдаанд оролцогчдын бүртгэл, мэдээллийг дуудлага худалдааг нээх хүртэлх хугацаанд бусдад мэдээлэхийг хориглоно.

Долоо. Дуудлага худалдааг эхлүүлэх, дуусгах

7.1. Дуудлага худалдаанд оролцохоор бүртгүүлж баталгаажсан оролцогчдод дуудлага худалдаа эхлэхээс цагаас 1 цагийн өмнө дуудлага худалдаа эхлэхийг анхааруулж цахимаар, утсаар, мессежээр мэдэгдэл хүргүүлнэ.

7.2. Товлосон цагт дуудлага худалдааг эхлүүлэхэд цахим системд орж ирээгүй оролцогчийг дуудлага худалдаанд оролцохоос татгалзсанд тооцож тэмдэглэл үйлдэж, дуудлага худалдааг эхлүүлнэ.

7.3. Дуудлага худалдаанд хэчнээн тоо толгой, ямар төрөл зүйл ан амьтны тусгай зөвшөөрөл оруулж байгааг танилцуулж оролцогчдоос анхны үнийн санал хэлснээр дуудлага худалдааг хүчин төгөлдөр болсонд тооцно.

7.4. Агнуурын амьтдыг агнах эрхийг толгой тус бүрээр дуудлага худалдаагаар олгоно.

7.5. Оролцогчид босго үнэ дээр өмнөх оролцогчийн өгсөн үнийн өсөн нэмэгдсэн дүн дээр өсгөн нэмэгдүүлэх зарчмаар үнийн санал хэлж өрсөлдөх;

7.6. Зохион байгуулагчаас тухайн дуудлага худалдааны ялагчийг зарлаж дуудлага худалдааг хааж, дараагийн дуудлага худалдааг эхлүүлнэ.

7.7. Дуудлага худалдааг тухайн өдрийн ажлын цагт эхлүүлж ажлын цагт хааж, дараагийн өдөр мөн ажлын цагт эхлүүлж ажлын цагт хаах зарчмаар тухайн аймагт хуваарилагдсан агнуурын амьтныг агнах эрхийг дэнчин төлж, хүсэлт ирүүлсэн тоо толгойн хэмжээгээр дуудлага худалдаагаар олгоно.

7.8. Дуудлага худалдаанд оролцогч өөрийн үнийн саналаа дуудлага худалдаа явуулах тусгай программ хангамжид бичгээр болон аудио/видео боломжийг ашиглан өгөх бөгөөд дуудлага худалдааны туршид программд нэвтрэх, бусад оролцогчдоос ирүүлсэн үнийн саналтай танилцах, өөрийн өгсөн үнийн санал баталгаажсан эсэхийг мэдэх аудио/видео бичлэгээр баримтжуулж баталгаажуулах боломжоор хангагдсан байна.

7.9. Дуудлага худалдааны үнэ хаялцах доод, дээд хязгаар

Тусгай зориулалтын ан	Босго үнэ /төгрөгийн хэмжээ/	Доод хязгаар / төгрөгийн хэмжээ/	Дээд хязгаар /төгрөгийн хэмжээ/
Угалз	4440000	500000	2000000
Тэх	1060000	150000	500000
Халиун буга	2540000	300000	1000000

7.10.Хуульд заасан үндэслэлээр дахин дуудлага худалдаа явуулахаар бол энэхүү удирдамжийг мөрдөнө.

7.11.Хуульд зааснаас бусад үндэслэлээр дуудлага худалдааг хүчингүй болгох, дахин дуудлага худалдаа явуулахыг хориглоно.

Найм. Дуудлага худалдаанд ялагчийг баталгаажуулах

8.1.Дуудлага худалдаа бүрэн дууссанаас хойш ажлын 2 хоногт багтааж хуульд заасан хугацаанд төлбөрөө төлсөн баримт, ажлын хэсгийн тэмдэглэл зэргийг үндэслэн дуудлага худалдаанд ялагчийг аймгийн засаг даргын захирамжаар баталгаажуулна.

8.2.Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч бол Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтыг баримтлан, тусгай зөвшөөрлийг өөрийн менежмент хариуцдаг агнуурын бүс нутаг дээр бүртгүүлж, мөн хуулийн 25.1-д заасан гэрээг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай байгуулна.

8.3.Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчаас өөр этгээд бол тухайн аймгийн аль нэг агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч болон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай гурвалсан гэрээ байгуулна.

8.4.Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах тусгай зөвшөөрлийг энэхүү удирдамжийн 8.2, 8.3-д заасан гэрээгээр агнуурын бүс нутагт олгохдоо агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөнд заасан тухайн жилд агнах амьтны дээд тооноос хэтрүүлэхгүй байна. Мөн аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалт, Менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөний хугацаа дууссан агнуурын бүсэд тусгай зөвшөөрөл олгож баталгаажуулахыг хориглоно.

8.5.Дуудлага худалдааны ялагчаас бусад оролцогчдын төлсөн дэнчинг ажлын 3 хоногт багтаан оролцогчдын дансанд буцаан шилжүүлнэ.

8.6.Дуудлага худалдааны ялагч нь ажлын 3 хоногт үлдэгдэл төлбөрөө төлөөгүй бол дэнчинг буцаан олгохгүй бөгөөд дараагийн үнийн санал хэлсэн иргэн хуулийн этгээдэд санал болгоно.

8.7.Хуульд зааснаас бусад үндэслэлээр дуудлага худалдаанд ялагчийг тодруулах, баталгаажуулах болон эс баталгаажуулах үйлдэл гаргахыг хориглоно.

Ес.Тусгай зориулалтаар ан агнах тусгай зөвшөөрлийн бичиг олгох

5.

9.1. Дуудлага худалдааны ялагчид дараах бичиг баримтын бүрдлийг үндэслэл болгон ан агнах тусгай зөвшөөрлийн бичиг олгоно. Үүнд:

9.1.1. Албан бичгээр ирүүлсэн хүсэлт

9.1.2. Энэхүү удирдамжийн 8.2 буюу 8.3-д заасан гэрээний хуулбар

9.1.3. Дуудлага худалдааны төлбөрийг бүрэн төлсөн баримт

9.1.4. Агнуурын нөөц ашигласны төлбөрийн 30%-ийг төлсөн баримт /Засгийн газрын 2017 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай төлбөртэйгөөр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хэмжээ”-г баримтлан төлбөрийг төлөх/

9.1.5. Агнуурын нөөц ашигласны хураамж 100% төлсөн баримт

9.1.6. Анчны паспортын хуулбар гэсэн бичиг баримтуудыг цахимаар хүлээн авч ан агнах зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн өдрөөс хойш ажлын 2 хоногт багтаан олгоно.

_____оОо_____